

Аудитын ерөнхий дүгнэлт: Төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагын ажилтнууд нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 70 гаруй хувийг бүрдүүлж байгаа боловч Эрүүл мэндийн даатгалын сангаас олгож буй тусламж үйлчилгээний хүртээмжийг хангалттай жигд хүртэж чадахгүй байна.

Аудитын нэр:

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН,
ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН
НЭРИЙН ДАНСАНД ХУРИМТЛАГДСАН
МӨНГӨН ХӨРӨНГИЙН БАЙДАЛ, ҮЙЛ
АЖИЛЛАГАА**

**Зуунмод
2014 он**

АГУУЛГА

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар.....3
ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт.....4-5
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	Аудитын дүн.....
Аудитын менежер О.Амаржаргал	БҮЛЭГ -1
Ахлах аудитор Ц.Базарсад Аудитор О.Сосор	Дүгнэлт 1
	Төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагын ажилтнууд нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 70 гаруй хувийг бүрдүүлж байгаа боловч Эрүүл мэндийн даатгалын сангаас олгож буй тусламж үйлчилгээний хүртээмжийг хангалттай жигд хүртэж чадахгүй байна.5-18
	БҮЛЭГ- 2
2014 оны 06 дугаар сарын 01	Дүгнэлт 1
	1995 оноос хойш тооцоолсон тэтгэврийн нэрийн дансны үлдэгдэл 2012 оны эцсийн байдлаар хийсвэр тоо байгаа учраас нэрийн данснаас тэтгэвэр авах эрх үүсэх нөхцөл бүрдээгүй байна.....19-20
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү. http://tuv-audit.mn/	БҮЛЭГ- 3
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273463 дугаарын утас, 7027-2582 дугаарын факсаар харилцана уу.	Дүгнэлт 1
	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны хийсвэр тооцоололд хяналт огт хийгдээгүй байна.... 21-22
ХАЯГ:	Дүгнэлт..... 23
Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	Зөвлөмж.....24
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал.....25

Товчилсон үгийн тайлбар

НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ҮАГ	Үндэсний аудитын газар
ААГ	Аймгийн аудитын газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
АНЭ	Аймгийн нэгдсэн эмнэлэг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны даргын 2014 оны 1-р сарын 28-ны 3 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөө, Төв аймгийн Аудитын газрын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт: Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд шалгаж дүгнэлт гарган, санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

- Иргэний эрүүл мэндийн даатгал нь хуульд заасан журмын дагуу даатгалын шимтгэл төлсөн, даатгалын санг урьдчилан бүрдүүлсэн, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг төлсөн байдал
- Тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх, уг дансны эхний үлдэгдэл, даатгуулагчийн төлсөн шимтгэл, хүүг тооцох, нэрийн данснаас тэтгэвэр тогтооход бэлэн эсэх
- Сангуудын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын байдал

Аудитын хамрах хүрээ: Аудитаар Эрүүл мэндийн даатгалын сангийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, хяналт шалгалтын байдал, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн орлого, хүүний тооцоололтын байдал бодитой байгаа эсэхийг 2013 оны тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан аудит хийв.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн хууль
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нэвтрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 1999 оны 6-р сарын 10-ны өдрийн 43 дугаар тогтоол
- Нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолууд
- Засгийн газар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн холбогдох тогтоол, шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан дүрэм, журам бусад холбогдох хууль тогтоомж, эрхийн актууд
- Төрийн аудитын тухай хууль

-Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

-Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт

Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн: Аудитыг Төв аймгийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, Ахлах аудитор Ц.Базарсад, аудитор О.Сосор нар 2014 оны 06-р сарын 01-нээс 07-р сарын 01-нийг хүртэл хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл: Аудитын ерөнхий зүйл, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн.

Бүлэг 1

Төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагын ажилтнууд нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 70 гаруй хувийг бүрдүүлж байгаа боловч Эрүүл мэндийн даатгалын сангаас олгож буй тусламж үйлчилгээний хүртээмжийг хангалттай жигд хүртэж чадахгүй байна.

Нэг. Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан хууль тогтоомжийн хэрэгжилт үр дүнтэй байна уу?

1.1.1 Эрүүл мэндийн даатгалын зөвлөл хуульд заасны дагуу ажиллаж байна уу.

Эрүүл мэндийн тухай хуулийн 5-р зүйлийн 5-д заасны дагуу Төв аймгийн Засаг даргын 2011.03.01-ны өдрийн 102 тоот захирамжаар Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих үүрэг бүхий аймгийн Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийг төрийн захиргааны байгууллагаас 3 ажилтан, даатгуулагчийн төлөөлөлөөс 3 иргэн, ажил олгогчийн төлөөлөлөөс 3 иргэний тус тус бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан байна.

Уг бүрэлдэхүүнд байсан Төрийн болон Үйлдвэрчний байгууллагуудын төлөөлөл болох ажилтнууд нь албан тушаалаасаа өөрчлөгдөөд 1-2 жил болсон байхад зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлаагүй байна.

Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөл ажиллаагүй тул эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтанд хяналт хийгдээгүй байна.

1.1.2.ЭМД-ын асуудал хариуцсан нэгжийн чиг үүрэг хуульд заасны дагуу ажиллаж байна уу

Иргэний эрүүл мэндийн тухай хуульд Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн заавал даатгуулах даатгалын үйл ажиллагааг эрхлэх нэгжтэй байж болно гэж заасны дагуу 2012 оноос Нийгмийн даатгалын хэлтэст эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааны алба байгуулагдсан байна.

Тус алба нь Эрүүл мэндийн даатгалын албаны дарга бөгөөд хяналтын улсын байцаагч эмч-1, эрүүл мэндийн даатгалын орлогын байцаагч-1, эрүүл мэндийн даатгалын сангийн төлбөр тооцоо, мэдээллийн сангийн бүрдүүлэлт хариуцсан байцаагч-1 нийт 3 орон тоотой ажиллаж байна.

Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын дэргэдэх Эрүүл Мэндийн Даатгалын газраас журам, аргачлал, зааврын эмхэтгэл /2006-2013/-ыг гарган сүлжээндээ байршуулж, нийгмийн даатгалын байцаагч нарыг мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллажээ.

2013 онд сумдын нийгмийн даатгалын байцаагч нарт 6 удаа сургалт, аж ахуй нэгж болон төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарт 4 сургалт зохион байгуулсан байна. Даатгагч, даатгуулагч, эрүүл мэндийн байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад Эрүүл Мэндийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн 2010.03.08-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан Иргэний Эрүүл Мэндийн Даатгалын хуулийг хэрэгжүүлэх журмыг мөрдөн ажилласан байна.

2013 онд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогоор 3002.2 сая төгрөг оруулахаас, гүйцэтгэлээр 3407.2 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 113.5 хувиар биелүүлсэн байна.

2013 оны эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2013.01.07-ны өдрийн 02 тоот тогтоолоор 2393.9 сая төгрөгөөр батласныг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2013.11.25 ны өдрийн 31-р тогтоолоор 2227.1 сая төгрөг болгон 166.8 сая төгрөгөөр бууруулан тодотгосон байна.

Батлагдсан 2227.1 сая төгрөгийн санхүүжилтээс, гүйцэтгэлээр 32 эрүүл мэндийн байгууллагад 2111.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ

Д/Д	Байгууллагын нэр	төлөвлөгөө	Гүйцэтгэл	биелэлт
1	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	1454.8	1432.2	98.4
2	Аксион трейд ХХК	77.9	49.3	63.3
3	Өвөржанчивлан рашаан сувилал	345.3	303.2	87.8
4	Задгай цагаан рашаан сувилал	69.7	67.4	96.7
5	Болдтрейд ХХК	65.1	65.1	100.0
6	Төв эм хангамж компани	153.8	142.4	92.6
7	Сумдын эмийн сангууд	60.2	51,8	86.1
	Нийт дүн	2227.1	2111.6	94.8

Эрүүл мэндийн сайдын 2011.03.09-ны өдрийн 99 тоот тушаалаар Эрүүл Мэндийн Даатгалын сангийн санхүүжилтээр 2011-2013 онд тусламж үйлчилгээ үзүүлэхээр сонгон шалгарсан аймаг, нийслэл, улс бүсийн хэмжээний үйлчилгээтэй хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагуудыг баталсан байна. Үүнд Төв аймгийн хэмжээнд:

- Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх эмнэлэг Аксион трейд ХХК,
- Сэргээн засах тусламж үзүүлэх сувилалаар Өвөржанчивлан ХХК, Задгай цагаан ХХК
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэхээр Аймгийн нэгдсэн эмнэлэг

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авах эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээ үзүүлэх улсын үйлчилгээтэй Аймгийн нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлэг Аксион трейд ХХК, Өвөржанчивлан ХХК, Задгай цагаан ХХК рашаан сувилалууд, стандартын шаардлага хангасан Болдтрейд ХХК, Монгол эм импекс компаний Төв аймгийн салбар, 26 сумын эмийн сангуудтай даатгалын гэрээ байгуулан ажилласан байна.

Эрүүл мэндийн байгууллагуудтай хийсэн гэрээнд даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрөл, үр дүнгийн үзүүлэлт, талуудын хүлээх үүрэг хариуцлага, гэрээний нөхцөл зэргийг тодорхой тусгасан байна.

Гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэхдээ даатгуулагчийн төлөөлөгч, өрхийн эмч нарын холбооны төлөөлөлийг оролцуулалгүйгээр зөвхөн Эрүүл мэндийн даатгалын албаны дарга буюу хяналтын байцаагч эмч, Эрүүл мэндийн даатгалын зарлагын байцаагч нар дүгнэсэн байна.

Энэ нь Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын 2012.12.05 ны өдрийн А/367 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн байгууллага хооронд байгуулсан даатгалын гэрээг дүгнэх журмын 3.-д заасан гэрээ дүгнэх багийн бүрэлдхүүнд, нийгмийн даатгалын байгууллага, эмнэлэг/сувилал/-ын хооронд байгуулсан гэрээг дүгнэхэд даатгуулагчийг төлөөлж 3 хүн /ЭМДЗ-ийн гишүүдээс/, нийгмийн даатгалын байгууллага эмийн сангийн хооронд байгуулсан гэрээг дүгнэхэд даатгуулагчийн төлөөлөл, өрхийн эмч нарын холбооны төлөөлөл тус тус 2 хүн байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12.2-т “даатгуулагчийн тусламж, үйлчилгээний зардлыг эмнэлгийн байгууллагад сарын хуваарийг үндэслэн урьдчилан төлж, гүйцэтгэлээр дараа сарын 25-ны дотор тооцон олгоно” гэсний дагуу санхүүжилтийг олгожээ.

Эрүүл мэндийн сайдын 2009.06.12-ны өдрийн 180 тоот тушаалаар Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж үйлчилгээний төлбөрийн арга, зардлын хэмжээг тооцох журмыг баталсан байна. Дээрх журмын 23-т нөхөн сэргээх үйлчилгээ нь рашаан сувилал, клиник сувилал, удаан хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ гэсэн хэлбэрүүдтэй байх ба оношийн хамааралтай бүлгийн 113,114,115 дахь бүлэг тус бүрээр санхүүжүүлнэ гэж заасны дагуу Өвөржанчивлан, Задгай цагаан сувилалын санхүүжилтийг 1 хүнд 74000 төгрөгөөр тооцон олгосон байна.

2012 онд Аудитын газраас хийсэн шалгалтаар Рашаан сувилалууд нь өвөл, хаврын улиралд хүн цөөнтэй ажиллаж, зуны цагаар ачаалал ихтэй батлагдсан ор хоногоос илүү санхүүжилт олгож байсныг залруулахаар албан шаардлага өгснөөр зөрчил арилсан байна. Өвөржанчивлан рашаан сувилал нь 150 ортой, Задгай цагаан сувилал 20 ортой. Сувилалын дундаж ор хоногийг 7.5-аар тооцон ачаалал ихтэй зуны саруудад Өвөржанчивлан сувилалыг 600 хүнээс хэтрүүлэхгүй, Задгай цагаан сувилалыг 80 хүнээс хэтрүүлэхгүйгээр санхүүжүүлсэн байна. Бусад саруудад батлагдсан орондоо хүрэхгүй цөөн хүнтэй ажилладаг тул сувилуулсан хүний тоогоор санхүүжилт олгосон байна.

Рашаан сувилалын сувилуулагчийн картийн иргэний регистрийн дугаарыг иргэний бүртгэлийн баазтай сар бүр тулган шалгахад даатгуулагчийн регистр зөрүүтэйгээс Өвөржанчивлан рашаан сувилалд 7 хүний 0.5 сая төгрөгийн санхүүжилт хасагдсан байна.

1.1.3.Хуультай холбогдуулан гаргасан дүрэм, журмын хэрэгжилт

Эрүүл Мэндийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн 2010.03.08-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан Иргэний Эрүүл Мэндийн Даатгалын хуулийг хэрэгжүүлэх журмын дагуу даатгагч, даатгуулагч, эрүүл мэндийн байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулан ажиллаж байна.

Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын даргын 2012.12.05-ны өдрийн А/367 тоот тушаалаар батлагдсан Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн байгууллага

хооронд байгуулсан даатгалын гэрээг дүгнэх журмын 3-т гэрээ дүгнэх багийн бүрэлдэхүүнд даатгуулагчийг төлөөлж 3 хүн байх гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

Иргэний эрүүл мэндийн тухай хуулийн 5.1.2-т заасан Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааг даатгалын зөвлөлд тайлагнах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хоёр.ЭМДС-ын орлогыг бүрэн төвлөрүүлж чадаж байна уу

1.2.1 Даатгуулагчийн төлсөн ЭМД-ын шимтгэл бүрэн төвлөрүүлж байна үү ?

Даатгуулагчийн төлөх ЭМД-ын шимтгэлийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Төв аймгийн хэмжээнд 2013 онд Эрүүл мэндийн даатгалын санд заавал даатгуулагчаас орох орлого төлөвлөгөөгөөр 1198.9 сая төгрөг, гүйцэтгэлээр 1220.3 сая төгрөг төвлөрч 101.7 хувиар, эрүүл мэндийн даатгалын хураамжийн орлого төлөвлөгөөгөөр 75.0 сая төгрөг, гүйцэтгэлээр 125.1 сая төгрөг төвлөрч 166.8 хувиар биелэжээ.

Даатгуулагчдаас оруулсан шимтгэл, хураамжийг тус бүрээр харуулбал:

- 780 ажил олгогч байгууллагад ажиллаж байгаа 15510 заавал даатгуулагчдаас 1220.3 сая төгрөг
- Эрүүл мэндийн хураамжаар 14180 хүнээс 125.1 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын хураамжид 19090 иргэн хамрагдахаас 14180 иргэн хамрагдаж 73.7 хувиар биелүүлсэн байна. Төлөвлөгөөний биелэлтээс дүгнэхэд хамрагдвал зохих иргэд 73.7 хувьтай, орлогын төлөвлөгөө 50.1 сая төгрөгөөр давж биелэсэн нь орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын 2476.6 сая төгрөг буюу 72.7 хувийг заавал даатгуулагчаас төлсөн шимтгэл эзлэж байна.

1.2.2 Ажил олгогчийн төлсөн ЭМД-ын шимтгэл бүрэн төвлөрүүлж байна үү ?

Ажил олгогчоос төлөх ЭМД-ын шимтгэлийг бүрэн төвлөрүүлсэн байна.

2013 оны Эрүүл мэндийн даатгалын санд ажил олгогчдоос төлөх шимтгэл төлөвлөгөөгөөр 1251.3 сая төгрөг, гүйцэтгэлээр 1277.7 сая төгрөг төвлөрч, 102.1 хувиар биелүүлсэн байна.

2013 оны жилийн эцсийн тайлангаар нийт 780 ажил олгогч байгууллагын нийт 65081.8 сая төгрөгийн цалингийн сангаас, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлсөн байна. Тайлант онд 135 ажил олгогч шинээр нийгмийн даатгалд хамрагджээ.

Сумдын Нийгмийн даатгалын байцаагч нар нь сумын төвлөрсөн дансанд аж ахуй нэгж болон төсөвт байгууллагуудаас төлсөн шимтгэлээс хуулиар тогтоосон хувиар тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн даатгал, ажилгүйдлийн сангуудад хуваарилаж байна. Лүн, Баянцагаан, Сэргэлэн, Баян, Батсүмбэр, Өндөрширээт, Эрдэнэсант, Баяндэлгэр, Архуст, Жаргалант, Сүмбэр сумдын НДСангуудын анхан шатны баримтыг шалгахад сумдын НДСангуудын зарцуулалтанд сумын


удирдлагаас тавих хяналтгүй, зарцуулалтанд 1-р гарын үсгийг тодорхой албан тушаалтанд хариуцуулаагүйгээс Засаг дарга, Засаг даргын орлогч, Төрийн сангийн төлөөлөгч зурахаас гадна дан ганц Нийгмийн даатгалын байцаагчийн гарын үсгээр гүйлгээ хийгдэж байна. Жишээлбэл:

- Баян сумын сангийн хувиарлалт зарцуулалтанд Засаг дарга 1-р гарын үсэг, НДБайцаагч 2-р гарын үсэг зурж сумын засаг даргын тамга дарж гүйлгээ хийгдсэн байна.
- Лүн, Баянцагаан, Сэргэлэн сумдын сангуудын хувиарлалт зарцуулалтанд Нийгмийн даатгалын байцаагч 1-р гарын үсэг зурж, байцаагчийн тэмдэг дарж гүйлгээ хийгдсэн байна.
- Бусад сумдын хувьд засаг дарга болон засаг даргын орлогч, тамгын газрын дарга, төрийн сангийн төлөөлөгчөөр зуруулсан байна.

Орон нутагт сумдын Нийгмийн даатгалын сангуудын зарлагын гүйлгээнд 1-р гарын үсэг зурах албан тушаалтанд эрх зүйн зохицуулалтгүй байна.

1.2.3 Төр даатгалыг хариуцах иргэдэд хүний хөгжлийн сангаас төлсөн шимтгэлийг төвлөрүүлж байна үү?

2013 оны жилийн эцсийн байдлаар Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн төр хариуцах иргэдийн мэдээллийн баазад 16 хүртэлх насны хүүхэд 26511, өндөр насны тэтгэвэр авагч 8606, хүүхдээ асарч буй эх 2790, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 1365, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 503, халамжийн тэтгэвэр авагч 1772, хугацаат цэргийн албан хаагч 405, нийт 41952 иргэн бүртгэлтэй байна.



2013 оны эхэнд төр хариуцах иргэдийн шимтгэлийн 70.4 сая төгрөгийн авлагатай байснаас тайлант онд 383.9 сая төгрөгийн ногдуулалт хийж, хүний

хөгжлийн сангаас 464.7 сая төгрөгийн санхүүжилт авч оны эцсийн байдлаар 10.4 сая төгрөгийн өглөг үүсжээ.

Хүний хөгжил сангаас хишиг, хувь хүртээх ажлыг Засгийн газрын 2010 оны 347 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын иргэн хишиг, хувь хүртэх журам"-д аймгийн нийгмийн даатгалын хэлтэс, сумдын нийгмийн даатгалын байцаагчид хүсэлт гаргасан иргэний Эрүүл мэндийн даатгалын гэрчилгээнд тухайн оны шимтгэлийг хүний хөгжлийн сангаас төлөв гэсэн тэмдэглэл хийж баталгаажуулна гэж заасан.

Энэ дагуу малчид болон ажил, хөдөлмөр эрхлээгүй иргэд Хүний хөгжил сангийн хишиг, хувийг эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр хэлбэрээр хүртэхээр хүсэлт гаргаагүй байна.

1.2.4 Сангийн чөлөөт үлдэгдэл банкинд хадгалуулсаны хүүгийн орлого байна уу ?

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь ХААН банкны Төв аймгийн салбар, Төрийн банкны Төв аймгийн салбаруудтай хамтран ажиллах гэрээ байгуулжээ. Гэрээний 2,3-т "Банк нь харилцах дансны өдөр тутмын үлдэгдэлд жилийн 5,5 хувийн хүүг өдөр тутам хуримтлуулан тооцож, сар бүрийн эцэст хүүгийн орлогын шилжүүлж харилцах дансанд хүүгийн орлого тооцсон болон шилжүүлсэн нэгдсэн тайланг НДХэлтэс бүрээр улирал тутамд НДЕГ-т гаргаж ирүүлнэ" гэсний дагуу ЭМД-ын санд 2013 онд ХААН банкны салбаруудаас 7.4 сая төгрөгийн, Төрийн банкны салбаруудаас 16.8 сая төгрөгийн нийт 24.2 сая төгрөгийн хүүгийн орлого бодогдон орсон байна.

Эрүүл мэндийн даатгалын сангуудын хөрөнгийг арилжааны банкуудад зориулалт бусаар байршуулаагүй байна.

1.2.5 Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх хугацааг хэтрүүлсэнд оногдуулсан алданги тооцож байна уу ?

Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх шимтгэлийн орлогыг байгууллагууд дутуу буюу буруу тооцдог зөрчилийг илрүүлэн холбогдох арга хэмжээ авсан байна. Тухайлбал 86 байгууллагатай холбоотой зөрчилд 2.6 сая төгрөгийн алданги тооцож бүрэн барагдуулж ажилласан байна. Алдангийн дүн нь 100,000 төгрөгөөс дээш дүнтэй байгууллагуудыг хүснэгтээр харуулбал:

		Толгой	төгрөгөөр
1	140000054	Эрдэнэ сургууль	100 710.45
2	140000084	Төв хөгжил	101 110.20
3	140200006	УБЦТС ХХК-ний Зуунмод ХҮТ	117 928.00
4	141200003	Таван эрдэнэ групп	122 997.00
5	142300011	Аргалант хосбэрс агро ХХК	162 000.00
6	142300017	Тусгал төв ХХК	267 036.00
7	142600003	Жаргалант тэн хун ХХК	462 685.15

1.2.6 Бусад орлого байна үү ?


Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2013 онд 65 байгууллагаас акт төлбөрийн орлогоор 5.9 сая төгрөг оруулсан байна. Актын дүнгээр 100.000 төгрөгөөс дээш аж ахуйн нэгж байгууллагуудыг хүснэгтээр харуулбал:

			төгрөгөөр
1	000025765	ЛҮН ТАМГЫН ГАЗАР	102 589.44
2	000025773	БАЯНЧАНДМАНЬ ЧАНДМАНЬ ЗЭНДМЭНЭ ХХК	108 000.00
3	000025786	ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР	120 960.00
4	000025790	БАЯНЦОГТ ЦЭЦЭРЛЭГ	127 944.00
5	000025793	УГТААЛ ТАМГЫН ГАЗАР	138 544.00
6	005000029	ТЗМ ХХК	158 541.04
7	005000035	БОРНУУР ТӨВ УРЛАН ХХК	180 936.00
8	140000028	ЭРДЭНЭСАНТ ХҮН ЭМНЭЛЭГ	184 831.00
9	140000032	ТӨВ ХӨГЖИЛ	202 220.00
10	140000039	УБЦТС ЗУУНМОД ХҮТ	235 855.24
11	140000054	ДЭВЖИХ БАТ ОРГИЛ ХХК	240 000.00
12	140000084	МОН ТӨВ ХХК	240 000.00
13	140200006	ТАВАН ЭРДЭНЭ ГРУПП	245 993.04
14	141200003	ЭРДЭНЭ СУРГУУЛЬ	321 939.28
15	142300011	АРГАЛАНТ ХОСБЭРС АГРО ХХК	324 000.00
16	142300017	ТУСГАЛ ТӨВ ХХК	557 958.00
17	142600003	ЖАРГАЛАНТ ТЭН ХҮН ХХК	921 024.00

Гурав. ЭМДСангаас гарах зардлыг хуулийн дагуу санхүүжүүлсэн үү


1.3.1.Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардлыг хуулийн дагуу олгогдож байгаа эсэх

Төв аймгийн хэмжээнд тусламж үйлчилгээний зардал олгохоор Аймгийн нэгдсэн эмнэлэг, Аксион мэдрэлийн эмнэлэгтэй гэрээ байгуулан ажилласан байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2013 онд төлөвлөгөөгөөр 1454.8 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1432.2 төгрөг авсан байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэг нийт 64797 хүнд үйлчилсэн бөгөөд авсан тусламж үйлчилгээний зардлыг оношийн бүлгээр задлан харуулбал:



Нийт тусламж үйлчилгээний зардлын 17 хувь буюу 240.6 сая төгрөгийг мэс заслын чиглэлийн амбулаторийн үйлчилгээ, 16 хувь буюу 230.8 сая төгрөгийг мэс заслын бус амбулаторийн үйлчилгээ, 12 хувь буюу 174.7 сая төгрөгийг оношлогоо шинжилгээ тус тус дийлэнх хувийг эзэлж байна.

Аксион мэдрэлийн эмнэлэг нь 2013 онд 77.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас нийт 492 хүнд 11 оношийн бүлгээр тусламж үйлчилгээ үзүүлэн эрүүл мэндийн даатгалын сангаас 49.3 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Тусламж үйлчилгээний зардлыг оношийн бүлгээр задлан харуулбал:



Мэдрэлийн тогтолцооны эмгэг хамгийн их буюу 29 хувийг эзэлж 14.1 сая төгрөг, Мигрен ба толгойн бусад өвдөлт 21% буюу 10.2 сая төгрөгийн тусламж үйлчилгээний санхүүжилтыг тус тус авсан байна.

2012 оны Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн 04 тоот тогтоолоор даатгуулагч жилдээ 1328000 төгрөгийн эмчилгээ, тусламж үйлчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт авах эрхтэй.

Төв аймгийн хэмжээнд 2013 онд нийт 99897 даатгуулагчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

2013 онд сумдын эмийн сан 8513 хүнд 51.8 сая төгрөг, Болдтрейд ХХК 10807 хүнд 65.1 сая төгрөг, Эм Импекс ХХК-ний төв салбар 27295 хүнд 142.4 сая төгрөгийн нийт 259.3 сая эмийн үнийн хөнгөлөлт үзүүлсэн байна.

2013 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас Өвөржанчивлан рашаан сувилал нь 330.2 сая төгрөг, Задгай цагаан рашаан сувилал нь 59.3 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Рашаан сувилалуудын санхүүгийн үзүүлэлтүүд /сая.төг/

Үзүүлэлтүүд	Өвөржанчивлан			Задгай цагаан		
	2012	2013	Өсөлт + бууралт -	2012	2013	Өсөлт + бууралт -
Борлуулалтын	1291.2	1412.5	121.3	261.2	288.9	27.7

орлого						
Үүнээс:ЭМДСангаас	311.1	330.2	19.1	81.1	67.4	-13.7
Үйл ажиллагааны зардал	1134.9	1221.2	86.3	240.4	265.5	25.1
Үүнээс:Цалин	279.5	327.3	47.8	33.8	53.5	19.7
НДШ	29.0	34.8	5.8	4.7	12.8	8.1
Ашиглалтын зардал	90.8	110.2	19.4	22.2	31.6	9.4
Эмийн зардал	5.1	7.1	2.0	4.8	1.8	-3.0
Хоолны зардал	214.7	226.9	12.2	115.1	126.0	10.9
Ор хоног	3870	4105	218	1149	911	-238

НДЕГазрын 2011.12.05-ны өдрийн А/367 тоот тушаалаар Нийгмийн даатгалын байгууллагатай даатгалын гэрээ бүхий рашаан сувилалд Эрүүл мэндийн даатгалд даатгуулсан даатгуулагч тусламж үйлчилгээ авсан тохиолдолд иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар төлбөрийн хөнгөлөлт эдэлдэг байна. Өвөржанчивлан, Задгай цагаан рашаан сувилал нь сувилуулагчийг рашаан сувилалд хүлээн аваад эмчийн үзлэгт хамруулан мэдээллийн санд бүртгэснээр “Сувилуулагчийн түүх”-ийг нээдэг байна. Эмчлэгч эмч нь сувилуулагчийн биеийн байдал, эмчилгээний тохироо үр дүнг хянаж үзлэгийн тэмдэглэлийг 3 хоног тутамд хөтөлж байна. Сувилалийн хугацаа дуусахад сувилалын эмчилгээний үр дүнгийн талаар сувилуулагчийн түүхэнд тэмдэглэл хийж, эмчилгээ сувилал, цаашдын дэглэмийн талаар зөвлөгөө өгч ажиллажээ.

Төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагын ажилтнууд нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 70 гаруй хувийг бүрдүүлж байгаа боловч нийт тусламж үйлчилгээ авсан иргэдийн 15 орчим хувийг эзэлж байгаагаас үзэхэд Эрүүл мэндийн даатгалын сангаас олгож буй тусламж үйлчилгээний хүртээмжийг хангалттай жигд хүртэж чадахгүй байна.

Аудитын явцад Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалаар хэрхэн үйлчлүүлж байгаа талаар даатгуулагчид болон Аймгийн нэгдсэн эмнэлэгийн эмч, ажиллагсдаас санал асуулга боловсруулж авсан. Санал асуулгад 466 иргэн хамрагдсанаас эмч нар 39, эмнэлэгийн ажиллагсад 89, ажилгүй болон тэтгэврийн насны иргэд 158, албан хаагч 180 хүн хамрагдсан.

Эмч нараас авсан санал асуулгаар:

- ЭМД-ын сангаас олоогддог санхүүжилт хуулийн дагуу зарцуулагдаж байна уу гэсэн асуултанд 60 хувь нь тийм, 30 хувь нь үгүй, 10 хувь нь мэдэхгүй,
- Эмийн үнийн хөнгөлөлт эдэлж байна уу гэсэн асуултанд 82.5 хувь нь тийм, 17.5 хувь нь үгүй,
- Гадуур истори нээлгэж эмчлүүлэх нь үр дүнтэй байна уу гэсэн асуултанд 80.0 хувь нь тийм, 20 хувь нь үгүй,
- Эмчлүүлэгчдэд хувиасаа авч хийлгэсэн эм тарианы зардлыг буцаан олгож байна уу гэсэн асуултанд 5 хувь нь тийм, 85 хувь нь үгүй, 10 хувь нь мэдэхгүй,
- Хэвтэн эмчлүүлэгчдийн дундаж ор хоног хэд байвал зохиостой вэ гэсэн асуултанд 90 хувь нь 7-10 хоног, 10 хувь нь 14 хоног гэж хариулсан байна.

Эмнэлгийн ажиллагчдаас авсан санал асуулгаар:

- ЭМД-ын сангаас ологогддог санхүүжилт хуулийн дагуу зарцуулагдаж байна уу гэсэн асуултанд 46 хувь нь тийм, 54 хувь нь үгүй,
- Эмийн үнийн хөнгөлөлт эдэлж байна уу гэсэн асуултанд 59.5 хувь нь тийм, 40.5 хувь нь үгүй,
- Иргэд хувиас эм тариа хийлгэсэн үү гэсэн асуултанд 70.7 хувь нь тийм, 29.3 хувь нь үгүй
- Эмчлүүлэгчдэд хувиасаа авч хийлгэсэн эм тарианы зардлыг буцаан олгож байна уу гэсэн асуултанд 4.4 хувь нь тийм, 95.6 хувь нь үгүй гэж хариулсан байна.

Иргэдээс авсан санал асуулгаар:

Аль салбар ажилладаг вэ гэсэн асуултанд 53.3 хувь төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагад ажиллагсад, 46.7 хувь нь тэтгэврийн болон ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд хамрагдсан байна.

- Та жилд хэдэн удаа хэвтэн эмчлүүлдэг вэ гэсэн асуултанд төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагад ажиллагсадийн 15 хувь нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлдэг, Тэтгэврийн болон ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн 85 хувь нь жилд 1-2 удаа хэвтэн эмчлүүлдэг гэсэн хариулт өгсөн.
- Иргэд эрүүл мэндийн даатгалаараа үйлчилгээ авч чадаж байна уу гэсэн асуултанд төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагад ажиллагсад, 21 хувь нь тийм, 79 хувь нь үгүй, Тэтгэврийн болон ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн 62 хувь нь тийм, 38 хувь нь үгүй гэж хариулсан байна.
- Хэвтэн эмчлүүлэгчдийн дундаж ор хоног хэд байвал зохиостой вэ гэсэн асуултанд төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагад ажиллагсадын 71.2 хувь нь 14 хоног, 28.8 хувь нь 10 хоног, Тэтгэврийн болон ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн 76.6 хувь нь 10 хоног, 23.4 хувь нь 7 гэж хариулсан байна.

Санал асуулгаас дүгнэж үзэхэд:

- Ажил алба хашиж байгаа иргэд эрүүл мэндийн даатгалаар хангалттай сэтгэл нийцсэн үйлчилгээ авч чадахгүй байна.
- Эмчлүүлэгчдэд хувиасаа авч хийлгэсэн эм тарианы мөнгийг эргүүлэн авч чаддаггүй байна.
- Заавал даатгуулагчид хэвтэн эмчлүүлэхэд улсын эмнэлэгт хэвтэх очер дугаар ихтэй учраас ихэнхдээ хувийн эмнэлгээр үйлчилүүлж, даатгалын хөнгөлөлт эдэлж чадахгүй байна.

1.3.2.Түс хуулийн 12.9-д заасан Эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх зардлыг хуулийн дагуу олгогдож байгаа эсэх.

Эмийн үнийн хөнгөлөлтийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн 2013 оны 07 дүгээр сарын 31-ний өдрийн 28 тоот тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалт, хөнгөлөх хувь, хэмжээ”-г шинэчлэн баталсан байна.

“Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2011” стандартад заавал мөрдөхөөр заасан норматив болох эмийн сангийн хүн хүчний хангамж, эмийн сангийн тавилга, тоног төхөөрөмжийн жагсаалт, эмийн сангийн өрөө тасалгааны хэмжээ, эмийн сангийн байрны хаяг, таних тэмдэг зэргийг мөрдөн үйл ажиллагаа

явуулж байгаа эмийн сангаар дамжуулан эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг даатгуулагчдын эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжлийн түвшинд хүргэх, даатгуулагчдад эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, тэднийг мэдээллээр хангах, эмийн сангууд төлбөр тооцоог заавал кассын машин буюу бар кодын машинаар хийсэнээр даатгуулагчаас илүү төлбөр төлүүлэх, өндөр үнэтэй эм худалдах зэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах нөхцөл бүрдсэн. Гэсэн хэдий ч бар код уншигчийг үйлчлүүлэгчийн дэргэд уншуулдаггүй, талон дээр гарын үсэг зуруулдаггүй, дараа нь шивж оруулдаг дутагдал арилахгүй байсаар байна.

Даатгуулагч нь хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэх эмийн жорыг харъяалах өрх, сум, багийн эмчээр бичүүлж, эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөр аймаг, дүүрэг, суманд төлснөөс үл хамааран оршин суугаа нутаг дэвсгэрт байрлах даатгалын гэрээ бүхий аль ч эмийн сангаар үйлчлүүлж хөнгөлөлттэй үнээр эм авах боломжтой болсон.

Аймгийн хэмжээнд зөвшөөрөл бүхий 28 эмийн сан, үүнээс Зуунмод суманд Болдтрейд ХХК, Монгол Эм Импекс Концерний Төв дахь салбар, 26 сумын эргэлтийн эмийн сантай даатгалын гэрээ байгуулан даатгуулагчид эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ үзүүлж байна.

2013 онд эрүүл мэндийн даатгалын сангаас 29589 даатгуулагч эмийн үнийн хөнгөлөлт эдэлсэн бөгөөд эдгээр даатгуулагчдын эмийн үнийн хөнгөлөлтийн зардалд эрүүл мэндийн даатгалын сангаас 259.3 сая төгрөг зарцуулсан байна.Үүнд:

Зуунмод сумын Монгол Эм Импекс Концерний харьяа Төв дахь салбарын эмийн сангаар давхардсан тоогоор 27295 иргэн үйлчлүүлж 142.4 сая төгрөгийн, Болдтрейд ХХК-ний эмийн сангаар давхардсан тоогоор 10807 иргэн үйлчлүүлж 65.1 сая төгрөгийн, Сумдын эргэлтийн эмийн сангаар 8513 хүнд 51.8 сая төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлт тус тус үзүүлсэн байна.

Даатгуулагч эмийн үнийн хөнгөлөлт эдлэх эрхийнхээ дагуу эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавих ёстой.

Тухайлбал Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлөөс тогтоосон эмийн үнийн дээд хязгаарыг баримтлахгүйгээр илүү өндөр үнээр эм худалдаалж байгаа эсэх, эмийн үнийн төлбөр тооцоог кассын машин, бар кодын машингүйгээр шууд бэлэн мөнгөөр хийж байгаа эсэхэд хяналт тавьж, хууль, журам зөрчсөн, шаардлага хангаагүй эмээр үйлчилсэн эмийн сангийн талаар мэргэжлийн хяналтын болон нийгмийн даатгалын байгууллагад хандан мэдээлэл өгч, эрх ашгаа хамгаалуулах үүрэгтэй боловч ийм тохиолдол гараагүй байна.

Бүх эмийн сангууд нь бар кодын машинтай тасалбарыг 2 хувь гарган 1 хувийг даатгуулагчид, 1 хувийг нь эмийн жортой нь хавсарган нийгмийн даатгалын байгууллагад ирүүлдэг. Жор нь бичигдсэн хугацаанаас хойш 10 хоногийн хугацаанд хүчинтэй байдаг. Сум, баг, өрхийн эмчийн бичсэн жороор эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлтийг үзүүлж байна.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2013 оны 07-р сарын 31-ний өдрийн 28 тоот тогтоолоор батлагдсан зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх жагсаалтыг мөрдөн ажиллаж байна. Нийт 212 эмийг 40-84 орчим хувийн хөнгөлөлттэй олгож байгаа бөгөөд эмийн хөнгөлөлтийн хэмжээ нь 100 төгрөгөөс 18000 хүртэл хөнгөлөгддөг бөгөөд энэ нь тоо хэмжээ ширхэгээс хамаарч өсөх боломжтой. Хамгийн их хөнгөлөгдөж байгаа эм нь Будесонид, хамгийн бага дүнгээр хөнгөлөгдөж байгаа нь парацетамол байна.

Тухайн өвчин эмгэгийн оношлогоо, эмчилгээний удирдамжийг баримтлан эмийн жорыг нэг удаад 5 хүртэл хоногийн тунгаар, 30 хүртэл хоногийн тунгаар бичиж олгож байна. Удаан хугацаагаар хэрэглэгдэх, тухайлбал уналт таталтын эсрэг, дааврын, цусны даралт, салга өвчин эмчлэх, сэтгэцийн эмгэгт хэрэглэх, чихрийн шижин эмчлэх, бамбай булчирхайн даавар, элэг хамгаалах, цусны үйл ажиллагаанд нөлөөлөх эм, бэлдмэлийг 30 хүртэлх хоногийн тунгаар бичиж олгож байна.

1.3.3. Эрүүл мэндийн үйл ажиллагааны зардлыг хуулийн дагуу санхүүжүүлсэн үү.

2013 онд аймгийн нэгдсэн эмнэлэг, Өвөржанчивлан сувилал, Задгай цагаан сувилал, Аксион эмнэлэг, Болд трейд эмийн сан, Төв эм хангамж эмийн сангууд болон 26 сумын эмийн эргэлтийн санд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал, сувилалын зардал, эмийн хөнгөлөлтийн зардал үзүүлэхээр гэрээ байгуулан ажилласан байна.

Тус байгууллагуудад олгох санхүүжилтын хэмжээ, төсвийг Нийгмийн даатгалын ерөнхий газар, Үндэсний зөвлөлөөс сар улирлын хуваариар батлан ирүүлдэг бөгөөд уг хуваарийн дагуу урьдчилгаа санхүүжилт олгон гүйцэтгэлийг хүлээн авч хянасны дараа үлдэгдэл санхүүжилтийг олгох зарчмаар санхүүжүүлэн ажилласан байна.

1.3.4. Энэ хуулийн 5.4 , 7.8, 9.3, 9.4, 12.14 дэх хэсэгт тус тус заасан зардлууд хуулийн дагуу санхүүжигдсэн эсэх

5.4-д “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан даатгалын зөвлөлийн дарга, гишүүдийг томилж даатгалын зөвлөлийн ажиллах журмыг талуудын саналыг үндэслэн батална. Даатгалын зөвлөлийн дарга, гишүүдэд ажлын оролцоог харгалзан урамшуулал олгож болно” гэж заасан. Эрүүл мэндийн Даатгалын зөвлөл ажиллаагүй учраас 2013 онд урамшуулалын зардал гараагүй байна.

7.8-д “Дараалсан гурван жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ аваагүй даатгуулагчийг нэг удаа эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамруулж урамшуулах бөгөөд журмыг нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална” гэж заасан байна. Даатгуулагчийг эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах эрхээр урамшуулах журмыг Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн 2009 оны 38 тоот тогтоолоор баталсан.

2013 онд Даатгуулагчийн эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй үзүүлэх эрхээр урамшуулах зардалд 2.7 сая төгрөг батлагдсан байна. Төв аймгийн хэмжээнд дараалсан 3 жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээ аваагүй даатгуулагч Нийгмийн даатгалын хэлтэст урамшуулалд хамрагдахаар хүсэлт ирүүлсэн боловч Эрүүл мэндийн үзлэгт хамрагдах нөхцлийг хангаагүйгээс урамшуулалын эрх эдэлсэн хүн байхгүй байна.

Даатуулагчид Нийгмийн даатгалын байгууллага дээр ирж мэдээлэл шүүлгэхэд эмнэлгийн тусламж, амбулатори үзлэг, шинжилгээ, эмийн үнийн хөнгөлөлтөнд хамрагдсан байдгаас эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамрагдах эрх үүсдэггүй байна.

Мөн 3 жил дараалан ЭМД-ын шимтгэлээ төлсөн боловч урамшуулалаар үзүүлэх үзлэгийн мөнгөний хэмжээ хэт багаас даатгуулагчид эрүүл мэндийн урамшуулалд хамрагдахаар хүсэлт гаргадаггүй байна.

9.3-д “Эрүүл мэндийн даатгалын сангийн 10 хувьтай тэнцэх хөрөнгийг болзошгүй эрсдлийн нөөцөд үлдээж болох бөгөөд түүнийг зарцуулах журмыг нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална” гэсэн дагуу Төв аймгийн нийгмийн даатгалын хэлтэст нөөцөд үлдээсэн хөрөнгө байхгүй байна. Санхүүгийн тайланд ЭМД-ын санд тайлагнасан хөрөнгө нь тухайн сар улирлын зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

9.4-д “Эрүүл мэндийн даатгалын сангийн хэмнэгдсэн үлдэгдлийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн шийдвэрийг үндэслэн хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, тэдгээрийн хүртээмж, хамралтыг нэмэгдүүлэхэд зарцуулж болно” гэсэн заалтын дагуу хөрөнгө зарцуулагдаагүй байна.

12.14-д “Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг харгалзан санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэн олгож болох бөгөөд журмыг нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална” гэсэн заалтын дагуу үр дүнг нь харгалзан санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэн санхүүжүүлсэн тохиолдол гараагүй байна.

1.3.5 ЭМД-ын хөрөнгийг болзошгүй эрсдлийн нөөцөд үлдээж байна үү?

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгөөс болзошгүй эрсдлийн нөөц бүрдүүлдэггүй бөгөөд тухайн сар улирлын орлогын биелэлт, зардлын санхүүжилтээс хамаарч Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгө нь их, бага хэмжээний үлдэгдэлтэй байдаг байна.

2013 онд эрүүл мэндийн даатгалын сангийн сар, улирлын үлдэгдлийг 740.0 сая төгрөгийг НДЕГГазар руу төвлөрүүлсэн байна.

1.3.6 ЭМДС-ын хэмнэгдсэн үлдэгдлийг хуулийн дагуу зарцуулж байна уу ?

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулаагүй үлдэгдэл нь дараа сар болон дараа оны санхүүжилтэнд олгодог. Мөн Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын даргын сангийн хөрөнгийн менежментийг сайжруулах тухай тушаалын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын дансанд 2013 онд ЭМД-ын сангаас нийт 740.0 сая төгрөгийн хөрөнгийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт төвлөрүүлсэн байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулаагүй үлдэгдэлийг НДЕГГазарт төвлөрүүлсэнээс өөрөөр зориулалт бус зүйлд зарцуулаагүй байна.

1.3.7 Эрүүл Мэндийн Даатгалын Сангаас гарсан зардлыг нөхөн төлүүлж байна уу ?

Эрүүл мэндийн байгууллага, рашаан сувилал, эмийн сангуудад сарын хуваарийн дагуу урьдчилгаа олгож гүйцэтгэлийг хүлээн авч хянасны дараа үлдэгдэл санхүүжилтийг шилжүүлдэг тул эрүүл мэндийн даатгалын сангаас гаргасан зардлыг нөхөн төлүүлэх зөрчил гараагүй байна

2013 онд эрүүл мэндийн байгууллага, эмийн сан, сувилалуудаас 2176.8 сая төгрөгийн хөнгөлөлт, эмчилгээ, сувилгааны баримтыг хүлээн авч, магадлагч эмчийн хяналтаар 65.2 сая төгрөгийг хасч 2111.5 сая төгрөгийг шилжүүлэхээр мэдээллийн баазад бүртгэсэн байна.

Тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх, уг дансны эхний үлдэгдэл, даатгуулагчийн төлсөн шимтгэл, хүүг тооцох, нэрийн данснаас тэтгэвэр тогтооход бэлэн эсэх

Бүлэг 2

Тэтгэврийн нэрийн дансанд 1995 оноос хойш тооцоолсон 2012 оны эцсийн үлдэгдэл хийсвэр тоо байгаа учраас нэрийн данснаас тэтгэвэр авах эрх үүсэх нөхцөл бүрдээгүй байна

2.1 Нэрийн дансыг хууль тогтоомжинд заасан нөхцөл, журмын дагуу нээсэн үү?

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нь тэтгэврийн даатгалын санд төлсөн шимтгэлийн хийсвэр тооцоолол бөгөөд 1960 он ба түүнээс хойш төрсөн даатгуулагчдад нээгдсэн байна. 2000 оноос хойш ажилд орсон иргэнд гарааны үлдэгдэл байхгүй, тэтгэврийн даатгалын санд шимтгэл төлсөн бол тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс автоматаар нээгдсэн, 2000 оноос өмнө ажиллаж байсан тохиолдолд гарааны үлдэгдэлтэй байна. Гарааны үлдэгдэл нь даатгуулагчийн 1999 оныг дуустал ажилласан хугацаа, 1995-1999 онд тэтгэврийн даатгалын санд төлсөн шимтгэлийн дүнд үндэслэн тооцогдсон байна.

2.2 Нэрийн дансны орлогын эх үүсвэр хуулийн дагуу бүрдэж байна уу?

Нэрийн дансыг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан нөхцөл журамд Тэтгэврийн даатгалд хамрагдсан 1960 оноос 1-р сарын 1-ны өдөр ба түүнээс хойш төрсөн Монгол улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа гадаадын иргэн болон харьяалалгүй хүнд нээнэ гэж заасны дагуу аймгийн хэмжээнд 2012 оны байдлаар 20021 иргэнд нэрийн данс нээж гарааны эхний үлдэгдэл 98309.1 сая төгрөг, даатгуулагчийн төлсөн шимтгэл 5933.0 сая төгрөг, нэрийн дансны орлогод тооцсон хүү 21425.4 сая төгрөг, нийт 125432.3 сая төгрөг тооцогдсон байна.

2.3 Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгө бодитой төвлөрсөн үү ?

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн төвөөс 2014.06.02-ны 76 тоотой ирүүлсэн судалгаагаар 2000-2012 оноор жил бүрээр даатгуулагчийн тоо, шинээр нэмэгдсэн даатгуулагч, эхний үлдэгдэл, хөдөлмөрийн хөлс, шимтгэл, үйл ажиллагааны зардал, бүртгэсэн шимтгэл, эхний үлдэгдлийн хүү, бүртгэсэн шимтгэлийн хүү, эцсийн үлдэгдлийг хийсвэрээр тооцогдсон тооцоололыг ирүүлсэн.

Аймгийн хэмжээнд 2012 оны жилийн эцсийн байдлаар 20021 даатгуулагчийн 125432.3 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын нэрийн дансанд хийсвэрээр хуримтлуулан тооцжээ.

Үндэсний Статистикийн Газар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлтэй зөвшилцөн 2013 оны нэрийн дансны орлого тооцох хүүгийн хэмжээг батлаагүй тул 2013 оны хүү нь тооцогдож, эцсийн үлдэгдэл нь гараагүй байна.

Нийгмийн даатгалын сангуудын 2013 оны жилийн эцсийн тайлангаар тэтгэврийн даатгалын сангийн үлдэгдэл 476.2 сая төгрөг байна.

Төв аймгийн хувьд тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлагаа бүрэн нөхдөггүй бөгөөд 2013 оны хувьд Нийгмийн Даатгалын Ерөнхий газраас тэтгэврийн даатгалын санд 16832.9 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Статитискийн тоон мэдээлэлээр аймгийн хэмжээнд 1960 онд төрсөн эмэгтэй 463, эрэгтэй 447, нийт 910 иргэд байна. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 7.1.1 “60 оны 1-р сарын 1 ба түүнээс хойш төрсөн 60 нас хүрсэн даатгуулагч эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл 180 ба түүнээс дээш тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч нэрийн данснаас өндөр насны тэтгэвэр авах эрхтэй” гэж заасан

2015 онд статитискийн тоон мэдээлэлээр 463 эмэгтэй тэтгэвэр тогтоолгох насанд хүрч нэрийн данснаас тэтгэвэр авах эрх үүсч байна. Гэтэл тэтгэврийн нэрийн дансанд 1995 оноос хойш тооцоолсон 2012 оны эцсийн үлдэгдэл хийсвэр тоо байгаа учраас нэрийн данснаас тэтгэвэр авах эрх үүсэх нөхцөл бүрдээгүй байна.

Бүлэг 3

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны хийсвэр тооцоололд хяналт огт хийгдээгүй байна.

3.1 Даатгалын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналт хийгдэж байна уу?

Төв аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн эрүүл мэндийн даатгалын алба нь эрүүл мэндийн даатгалын сангаас олгох тусламж үйлчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлтөнд хяналт тавьж, эмнэлгийн хуудас өвчтөний түүх, эмчийн жор, холбогдох журналуудыг хүлээн авч шалган санхүүжүүлдэг байна.

2013 онд ЭМД-ын сангаас илүү олгосон болон нөхөн төлүүлсэн зардал байхгүй, сарын эхээр санхүүжилтийн урьдчилгааг хамтран ажиллахаар байгуулсан гэрээнд заасан хэмжээгээр тухайн байгууллагуудад шилжүүлж гүйцэтгэлийг хүлээн авч хянахдаа шаардлага хангахгүй, эрх үүсэхгүй зардлуудыг хасч гүйцэтгэлээр санхүүжүүлж байна.

2013 онд ЭМД-ын сангаас санхүүжилт авахаар гэрээ байгуулсан 32 аж ахуйн нэгж байгууллагаас 2176.8 сая төгрөгийн тусламж үйлчилгээний зардлын баримт хүлээн авч, шаардлага хангаагүй 65.2 сая төгрөгийн зардлыг хасч 2111.5 сая төгрөгийн санхүүжилтыг олгосон байна.

№	Эмнэлгийн нэр	Нийт.Нэх.Дүн	Нийт.Нэх.Тоо	Нийт.Төл.Дүн	Нийт.Төл.Тоо	Байц.Дүн	Байц.Тоо
1	НЭГДСЭН ЭМНЭЛЭГ	1 490 230	67 918	1 432 214	64 807	58 015	3 111
2	АКСИОНТРЕЙД ХХК	49 935	498	49 327	492	608	6
3	Задгай цагаан	67 414	911	67 414	911	-	-
4	ЭРДЭ ӨВӨРЖАНЧИВЛАН РАШААН	303 770	4 105	303 252	4 098	518	7
5	Болд Трейд ХХК	66 262	5 396	65 104	5 346	1 158	50
6	ТӨВ ЭМ ХАНГАМЖ КОМПАНИ	145 071	14 484	142 446	14 287	2 624	197
7	АЛТАНБУЛАГ ХҮН ЭМНЭЛЭГ	3 683	992	3 474	973	208	19
8	АРГАЛАНТ ХҮН ЭМНЭЛЭГ	1 396	256	1 273	241	123	15
9	АРХУСТ ЭМИЙН САН	925	258	878	254	46	4
10	БАТСҮМБЭР ХҮН ЭМНЭЛЭГ	865	68	788	67	77	1
11	Баян сум эмнэлэг	3 044	495	2 924	482	119	13
12	БАЯНДЭЛГЭР ХҮН ЭМНЭЛЭГ	2 189	241	2 052	231	137	10
13	Баянөнжүүл хүн эмнэлэг	691	101	689	100	2	1
14	Баянжаргалан хүн эмнэлэг	1 305	448	1 234	432	71	16
15	Баянхангай хүн эмнэлэг	1 265	204	1 245	200	20	4
16	БАЯНЦАГААН ХҮН ЭМНЭЛЭГ	1 849	467	1 781	460	68	7
17	БАЯНЦОГТ ХҮН ЭМНЭЛЭГ	1 869	565	1 804	557	66	8
18	Баянчандмань хүн эмнэлэг	2 314	373	2 292	368	22	5
19	Бүрэн хүн эмнэлэг	1 113	379	1 069	374	44	5
20	Борнуур хүн эмнэлэг	3 200	524	3 147	510	54	14
21	ДЭЛГЭРХААН ХҮН ЭМНЭЛЭГ	1 293	226	1 232	223	61	3
22	ӨНДӨР ХҮН ЭМНЭЛЭГ	1 536	199	1 434	191	102	8
23	Жаргалант хүн эмнэлэг	3 470	461	3 225	437	245	24
24	Заамар хүн эмнэлэг	3 572	437	3 532	432	40	5
25	ЛҮН ХҮН ЭМНЭЛЭГ	2 048	358	1 956	339	92	19
26	Мөнгөнморьт хүн эмнэлэг	2 367	355	2 264	342	103	13
27	СҮМ ХҮН ЭМНЭЛЭГ	1 197	454	1 136	435	61	19
28	Сэргэлэн хүн эмнэлэг	1 457	296	1 279	272	178	24
29	УГТААЛ ХҮН ЭМНЭЛЭГ	924	218	873	209	51	9
30	ЦЭЭЛ ХҮН ЭМНЭЛЭГ	2 874	563	2 728	538	146	25
31	Эрдэнэ	2 266	298	2 158	283	108	15
32	Эрдэнэсант	5 455	1 020	5 374	1 006	81	14
Нийт дүн		2 176 847.53	103 568.00	2 111 598.47	99 897.00	65 249.06	3 671.00

Эмийн сангийн хувьд ихэвчлэн гардаг алдаанууд нь жор бичилт, олголттой холбоотой гардаг байна. Эмийн жорын хүчинтэй хугацаа дууссан, бар кодын тасалбаргүй, эмийн тоо ширхэг, тун хэмжээ зассан, он саргүй жороор эм олгосон, эмчийн тамгагүй, эмчийн шифр гарын үсэггүй, тухайн даатгуулагчийн мэдээлэл алдаатай, эрүүл мэндийн хураамж төлөөгүй зэрэг зөрчил гарснаас санхүүжилт хасаж тооцогддог байна. Мөн зайлшгүй шаардлагатай эмийг 5 хоногийн тунгаар, 30 хоногийн тунгаар олгох эмүүд, нэг жорон дээр бичигдэх эмийн дээд хязгаарыг заасан байдаг ба энэ хэмжээг хэтрүүлэн олгосон зэрэг зөрчлийг илрүүлэн анхааруулах арга хэмжээ авч ажиллаж байна. Өрхийн эмч нар нь эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жоронд хөнгөлөлтөнд хамрагдахгүй бусад эмийг бичдэг зөрчил илэрч байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэг болон Аксион трейд хувийн эмнэлгийн өвчтөний түүхүүд болон гүйцэтгэлийг нь файлаар болон цаасаар авч гүйцэтгэлийг хянаж үзээд холбогдох баримт материалыг архивлан жор, өвчний түүхүүдийг эрүүл мэндийн байгууллагуудад буцааж өгдөг байна. Эрүүл мэндийн байгууллагууд нь нэхэмжлэх материалын жагсаалтыг файлаар илгээсний дараа эрүүл мэндийн зардлын байцаагч бүх файлыг татан регистрийн дугаарыг иргэний бүртгэлийн болон өөрийн мэдээллийн сантай тулган эрүүл мэндийн даатгалын хураамж төлсөн эсэхийг хянаж, нэхэмжилсэн дүнг жагсаалтын дүнтэй тулган шалгасны дараа хяналтын байцаагч эмч өвчтөний түүх, жор зэргийг эх материалуудтай тулган хянаж өөрийн хяналтын программ, баазад байгаа мэдээллээ ашиглан шалгаж байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн өвчтөний түүх, амбулаторийн үзлэг, оношлогоо шинжилгээний материал нэхэмжлэхийг шалгахад нийтлэг гардаг алдаа дутагдлууд нь хавдар, процеллёз, сүрьеэ, сэтгэцийн эмгэгүүд, урьдчилан сэргийлэх үзлэгүүд, жирэмсэний болон идэвхтэй хяналтын үзлэгүүд, нярайн хүүхдүүд 0-28 хоногтой, осол гэмтлийн шалтгаантай эмгэгүүд, оношлогоо шинжилгээнд өөрчлөлтгүй байх, амбулаториор эмчлэх боломжтой өвчнүүдийг хэвтүүлэн эмчилсэн байх, тавьсан оношоо шинжилгээгээр баталгаажуулаагүй байх, оношийн бүлэг зөрүүлж нэхэмжлэсэн, даатгуулагч өөрөө хариуцан төлсөн 10 хувийг давхар нэхэмжлэх, даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын дэвтэрт бичилт баталгаажуулалт хийгээгүй байхад хэвтүүлсэн, даатгуулагчийн регистрийн дугаар иргэний бүртгэлийн баазад алдаатай байснаас программд орохгүй байх зэрэг нийтлэг зөрчлүүд илэрсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын хяналтын улсын байцаагчын хяналтаар 144 хүний 25.5 сая төгрөгийг санхүүжилтээс хасаж тооцон санхүүжүүлсэн байна.

3.2 Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт хийгдэж байна уу?

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тусгай удирдамжийн дагуу ямар нэгэн хяналт, шалгалт огт хийгдээгүй байна.

Нийгмийн даатгалын улсын байцаагч сум, байгууллагуудын Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын бүрдүүлэлтэнд шалгалт хийхдээ даатгуулагчийн цалин хөлс, регистрийн дугаарын давхардал зэрэг буруу орсон мэдээлэлийг засах тухай бүрт хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтрийн бичилтэнд хяналт хийгддэг байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөл ажиллаагүй тул эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтанд хяналт хийгээгүй байна.
2. Эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын гэрээг өрхийн эмч, даатгуулагчийн төлөөлөлийг оролцуулалгүй дүгнэсэн байна.
3. Эрүүл мэндийн даатгалын хураамжид 19090 иргэн хамрагдахаас 14180 иргэн буюу 73.7 хувь нь хамрагдсан байхад, орлогын төлөвлөгөө 50.1 сая төгрөгөөр давж биелэсэн нь орлогыг бодитой төлөвлөөгүй байна.
4. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын 2476.6 сая төгрөг буюу 72.7 хувийг заавал даатгуулагчаас төлсөн шимтгэл эзлэж байна.
5. 1995 оноос хойш тооцоолсон тэтгэврийн нэрийн дансны үлдэгдэл 2012 оны эцсийн байдлаар хийсвэр тоо байгаа учраас нэрийн данснаас тэтгэвэр авах эрх үүсэх нөхцөл бүрдээгүй байна.
6. Орон нутагт сумдын Нийгмийн даатгалын сангуудын зарлагын гүйлгээнд 1-р гарын үсэг зурах албан тушаалтанд эрх зүйн зохицуулалтгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Нийцлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Ч.Болормаад зөвлөх нь:

- Эрүүл мэндийн даатгалын сангийн хураамжийн орлогыг бодитой төлөвлөх
- Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн ажиллуулах
- Нэрийн дансны үлдэгдлийг бодитоор тооцож, нэрийн дансанд байршуулах арга хэмжээ авч хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар эрх бүхий байгууллагууд санал тавьж шийдвэрлүүлэх
- Эмийн сангуудад хөнгөлттэй эмийн жороор олголтыг нарийн шалгаж, бар код уншигч машины дүнг үйлчилүүлэгч бүрийн гарын үсгээр баталгаажуулж байх
- Сумдын Нийгмийн даатгалын сангуудын зарцуулалтын 1-р гарын үсгийг зурах тодорхой албан тушаалтанд хариуцуулах

Холбогдох байгууллагын санал
Холбогдох байгууллагын санал